



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/54

Бор-Өндөр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын 17 дугаар жарны Хилэнт эх хэмээх модон луу жилийн сар шинийн Нийтийн золголтын арга хэмжээнд ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд “Цаг тооны бичиг” худалдан авсан зардал болох 825 000 (найман зуун хорин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.
2. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах 825 000 (найман зуун хорин таван мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ